ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2022/55/НА-СА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: peakomaudit@gmail.com<br>Дархан-Уул аймаг<br>2022 он | Тэргүүлэх аудиторын албан үүргийг<br>түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: m**unkhbayarsh@audit.gov.mn**<br>Ахлах аудитор: **С.Батцэцэг**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: battsetsegs@**audit.gov.mn**<br>Аудитор: **А. Мөнхцэцэг**<br>Утас: **9904-1628**<br>Цахим хаяг: peakomaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Материаллаг байдал ........ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
3.8 Аудитын гол асуудал ........ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.25 № 153

танай ______________-ны № ______________-т

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Г.БАТ-ЭНХ ТАНАА

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Ш.МӨНХБАЯР/

0090?0?71

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,056,852.00** | **49,584,882.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **37,056,852.00** | **49,584,882.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **37,056,852.00** | **49,584,882.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 19,480.00 | 34,720.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,970,872.00 | 45,595,322.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 66,500.00 | 3,954,840.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **562,654,411.04** | **615,833,447.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **562,654,411.04** | **615,833,447.17** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **557,600,261.12** | **611,090,372.29** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 564,032,566.01 | 662,795,681.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (68,377,363.20) | (102,094,014.53) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 42,079,600.00 | 46,139,600.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,748,579.40) | (26,595,504.46) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 44,021,859.10 | 44,021,859.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,615,589.50) | (29,451,241.22) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 298,205.55 | 298,205.55 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (74,551.44) | (111,827.16) |
| 39217 | Ном | 14,984,114.00 | 16,087,614.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **5,054,149.92** | **,743,074.88** |
| 39301 | Програм хангамж | 1,244,300.00 | 1,244,300.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (622,150.08) | (933,225.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,432,000.00 | 4,432,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **599,711,263.04** | **665,418,329.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **100,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **100,000.00** |
| **41300** | **Өглөг** | **-** | **100,000.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **-** | **100,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 100,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **599,711,263.04** | **665,318,329.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **599,711,263.04** | **665,318,329.17** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 103,614,645.49 | 103,614,645.49 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(191,881,861.00)** | **(126,274,794.87)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (174,110,090.10) | 191,881,861.00) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (17,771,770.90) | 65,607,066.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 687,978,478.55 | 687,978,478.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **599,711,263.04** | **665,418,329.17** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **162,756,200.00** | **288,481,215.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,320,000.00** | **98,763,115.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,320,000.00** | **98,763,115.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 12,320,000.00 | 98,763,115.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150,436,200.00** | **189,718,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **558,000.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 558,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **149,878,200.00** | **189,718,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 149,878,200.00 | 189,718,100.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **179,855,495.90** | **222,874,148.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **179,855,495.90** | **222,874,148.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **178,748,442.42** | **191,885,999.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **64,876,177.00** | **68,242,827.97** |
| 210101 | Үндсэн цалин | 47,861,839.49 | 47,923,188.39 |
| 210102 | Нэмэгдэл | 11,970,137.51 | 20,319,639.58 |
| 210104 | Урамшуулал | 5,044,200.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **8,733,107.52** | **9,663,762.47** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,028,830.20 | 6,813,428.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 711,355.24 | 729,784.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 535,485.26 | 611,522.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 132,494.77 | 219,949.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,324,942.05 | 1,289,076.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,492,782.00** | **38,104,160.40** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,139,574.00 | 871,176.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,895,400.00 | 36,933,966.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,457,808.00 | 299,018.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,633,209.00** | **2,018,010.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 868,120.00 | 556,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 528,584.00 | 590,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 432,296.00 | 457,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,000.00 | 7,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 643,800.00 | 405,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,995,409.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,251,900.00** | **19,787,060.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,251,900.00 | 19,787,060.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **287,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 287,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **600,000.00** | **2,333,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 333,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,874,266.90** | **51,736,578.87** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,693,000.00 | 989,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,181,266.90 | 50,747,578.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,107,053.48** | **30,988,149.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **250,200.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 250,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **807,053.48** | **30,737,949.16** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 807,053.48 | 30,737,949.16 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(17,099,295.90)** | **65,607,066.13** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **672,475.00** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 672,475.00 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(17,771,770.90)** | **65,607,066.13** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **103,614,645.49** | **690,034,716.55** | **(176,166,328.10)** | **617,483,033.94** |
| **2** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,056,238.00 | 2,056,238.00 |
| **3** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 103,614,645.49 | 690,034,716.55 | (174,110,090.10) | 619,539,271.94 |
| **4** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (2,056,238.00) | - | (2,056,238.00) |
| **5** | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| **6** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| **7** | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| **8** | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **(17,771,770.90)** | **(17,771,770.90)** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **103,614,645.49** | **687,978,478.55** | **(191,881,861.00)** | **599,711,263.04** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **103,614,645.49** | **687,978,478.55** | **(191,881,861.00)** | **599,711,263.04** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 103,614,645.49 | 687,978,478.55 | (191,881,861.00) | 599,711,263.04 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 65,607,066.13 | 65,607,066.13 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **103,614,645.49** | **687,978,478.55** | **(126,274,794.87)** | **665,318,329.17** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **150,436,200.00** | **189,718,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150,436,200.00** | **189,718,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **558,000.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 558,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **149,878,200.00** | **189,718,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 149,878,200.00 | 189,718,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **141,107,200.00** | **184,554,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **141,107,200.00** | **184,554,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **140,000,146.52** | **153,566,450.84** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **64,876,177.00** | **68,142,827.97** |
| 210101 | Үндсэн цалин | 47,861,839.49 | 47,942,820.97 |
| 210102 | Нэмэгдэл | 11,970,137.51 | 20,200,007.00 |
| 210104 | Урамшуулал | 5,044,200.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **8,733,107.52** | **9,663,762.47** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,028,830.20 | 6,813,428.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 711,355.24 | 729,784.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 535,485.26 | 611,522.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 132,494.77 | 219,949.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,324,942.05 | 1,289,076.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **46,492,782.00** | **38,104,160.40** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,139,574.00 | 893,636.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,895,400.00 | 36,911,506.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,457,808.00 | 299,018.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,592,780.00** | **3,203,800.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 831,900.00 | 531,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 528,584.00 | 529,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 432,296.00 | 518,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 178,150.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,620,000.00 | 1,445,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **210,600.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 210,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,105,400.00** | **30,922,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,787,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,318,400.00 | 30,922,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **287,000.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 287,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,099,900.00** | **2,333,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,499,900.00 | 2,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 333,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,813,000.00** | **985,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,813,000.00 | 985,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,107,053.48** | **30,988,149.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **250,200.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 250,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **807,053.48** | **30,737,949.16** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 807,053.48 | 30,737,949.16 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **9,329,000.00** | **5,163,500.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **9,329,000.00** | **5,163,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,329,000.00** | **5,163,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **9,329,000.00** | **5,163,500.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,329,000.00 | 5,163,500.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(9,329,000.00)** | **(5,163,500.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **201,391,600.00** | **158,980,150.84** | **(42,411,449.16)** | **78.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **201,391,600.00** | **158,980,150.84** | **(42,411,449.16)** | **78.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **201,141,400.00** | **158,729,950.84** | **(42,411,449.16)** | **78.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **96,222,000.00** | **68,142,827.97** | **(28,079,172.03)** | **70.82** |
| 210101 | Үндсэн цалин | 66,271,700.00 | 47,942,820.97 | **(18,328,879.03)** | **72.34** |
| 210102 | Нэмэгдэл | 21,090,100.00 | 20,200,007.00 | **(890,093.00)** | **95.78** |
| 210104 | Урамшуулал | 8,860,200.00 | - | **(8,860,200.00)** | **1.00** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **13,014,200.00** | **9,663,762.47** | **(3,350,437.53)** | **74.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,158,200.00 | 6,813,428.84 | **(2,344,771.16)** | **74.40** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 964,000.00 | 729,784.95 | **(234,215.05)** | **75.70** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 771,200.00 | 611,522.79 | **(159,677.21)** | **79.29** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 192,800.00 | 219,949.28 | **27,149.28** | **114.08** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,928,000.00 | 1,289,076.61 | **(638,923.39)** | **66.86** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,729,800.00** | **38,104,160.40** | **(10,625,639.60)** | **78.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,608,800.00 | 893,636.00 | **(2,715,164.00)** | **24.76** |
| 210302 | Түлш, халаалт | 43,755,000.00 | 36,911,506.40 | **(6,843,493.60)** | **84.36** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,366,000.00 | 299,018.00 | **(1,066,982.00)** | **21.89** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,307,300.00** | **4,307,300.00** | **-** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 531,900.00 | 531,900.00 | **-** | **100.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 530,000.00 | 529,750.00 | **(250.00)** | **99.95** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 520,000.00 | 518,600.00 | **(1,400.00)** | **99.73** |
| 210404 | Ном, хэвлэл | 1,100,000.00 | 1,103,500.00 | **3,500.00** | **100.32** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 178,150.00 | **(1,850.00)** | **98.97** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,445,400.00 | 1,445,400.00 | **-** | **100.00** |
| **2105** | **Нормативт зардал** | **210,600.00** | **210,600.00** | **-** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 210,600.00 | 210,600.00 | **-** | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **34,982,700.00** | **34,982,700.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 34,982,700.00 | 34,982,700.00 | **-** | **100.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,374,800.00** | **2,333,600.00** | **(41,200.00)** | **98.27** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,003,200.00 | 2,000,000.00 | **(3,200.00)** | **99.84** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 333,600.00 | 333,600.00 | **-** | **100.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,000,000.00** | **985,000.00** | **(15,000.00)** | **98.50** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 985,000.00 | **(15,000.00)** | **98.50** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **250,200.00** | **250,200.00** | **-** | **100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **250,200.00** | **250,200.00** | **-** | **100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250,200.00 | 250,200.00 | **-** | **100.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **201,391,600.00** | **158,980,150.84** | **(42,411,449.16)** | **78.94** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **201,391,600.00** | **158,980,150.84** | **(42,411,449.16)** | **78.94** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 201,391,600.00 | 158,980,150.84 | **(42,411,449.16)** | **78.94** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **19.00** | **17.00** | **(2.00)** | **89.47** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **-** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | **-** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **9.00** | **8.00** | **(1.00)** | **88.89** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | **-** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 5.00 | **-** | **100.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 2.00 | **(1.00)** | **66.67** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **9.00** | **8.00** | **(1.00)** | **88.89** |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 6.00 | 2.00 | **(4.00)** | **33.33** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 6.00 | **3.00** | **200.00** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор А. Мөнхцэцэг, аудитор Б.Оюунцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б. Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шарын гол сумын Соёлын төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шарын гол сумын Соёлын төв нь "сумын нийт ард иргэдэд соёлыг түгээж хүүхэд залуучуудад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд оршино" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус төвийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 180,155.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,798.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,259.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шарын гол сумын соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,707.0 мянган төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 37,056.9 | 49,584.9 | 12,528.0 |
| Үндсэн хөрөнгө | 562,654.4 | 615,833.4 | 53,179.0 |
| Нийт хөрөнгө | 599,711.3 | 665,418.3 | 65,707.0 |
| Өр төлбөр | - | 100.0 | 100.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 599,711.3 | 665,318.3 | 65,607.0 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 599,711.3 | 665,418.3 | 65,707.0 |

Бараа материал дансны үлдэгдэл 12,528.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 33,809.9 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдав авч, тайлант хугацаанд 21,281.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,163.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, орон нутгийн санхүүжилтаар барилгын урсгал засварт 98,763.1 мянган сайжруулалт хийж, 50,747.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 615,833.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 665,318.3 мянган төгрөг болж 65,607.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 125,725.0 мянган төгрөгөөр буюу 77.0 хувиар өссөн нь орон нутгийн төсвийн санхүүжилт 39,839.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 86,443.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 43,018.6 мянган төгрөгөөр буюу 24 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил 3,366.6 мянга, эд хогшил урсгал засварын зардал 14,535.2 мянган төгрөгийн зардлууд байна. Энэ нь барилгын дотор урсгал засвар, гадна фасадны ажил хийсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 195,003.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 41,878.4 мянган төгрөгөөр бууруулж, 153,124.6 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 9,680.1 мянга, байр ашиглалтын зардлыг 7,402.1 мянга, урсгал засварын зардлыг 24,338.7 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 51,946,1.7 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 37,924.4 мянган төгрөгөөр тус тус өндөр байгаа нь тайлант жилд ажилчидын цалин хөлс, нэмэгдлийг 100 хувь олгох,4 ажилтаны цалингийн шатлал ахиулах, байрны халаатыг 8

сараар авах, ажлын байрны дотор засвар үйлчилгээг хийнэ гэж тооцоолон төсөвлөснөөс шалтгаалжээ.

Төсвийн тодотголоор 201,391.6 мянган төгрөг болгож 48,267.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь тайлант хугацаанд барилгын гадна болон дотор урсгал засварын ажил хийхтэй холбоотой юм.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 201,391.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 189,718.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 158,980.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 30,737.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 158.980.2 мянган төгрөг буюу 78.94 хувьтай байна. 2021 онд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 31,609.6 мянга, тогтмол зардал 10,625.6 мянга, төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын гүйлгээ гараагүй байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**3.8 Аудитын гол асуудал**

Дархан -Уул аймгийн Шарын гол сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 13 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцгүй гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны цахим хуудсанд орлого, зарлагын мэдээллийг хуримталуулан бөөн дүнгээр оруулсан байсан. Биелэлтийг 2021 оны 10 сарын 19-ны өдрийн 48 тоот албан бичигээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,682.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 16,868.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 22,814.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

- Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлан 12,808.1 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн
- Бараа материалын дансанд 4,060.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэн авсныг тус тус залруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт***

*1.1. Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, үнийн дүн, тоон үзүүлэлтгүй хугацаа хоцроосон 13 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж байх талаар зөвлөмж хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дархан-Уул аймгийн Шарын гол сумын соёлын төв | 3 | 39,682.2 | 2 | 16,868.1 | - | - | 0 | 0 | 1 | 22,814.1 |
| | Дүн | 3 | 39,682.2 | 2 | 16,868.1 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 22,814.1 |

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25